ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2017.2.22 № 344.

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.ГАНБОЛД ТАНАА

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ, аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж байна.

Хавсралт 20 хуудас

ДЭД ДАРГА С.ЭНХБААТАР

D:\2017 on\yavuulsan bichig\2017.02.22 NNBTS HOROO .A5.docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2017.2.20. № 296.
танай ____________ -ны № ____________ -т

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА Ж.ГАНБОЛД ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

**Зөрчилгүй санал үндэслэл:**

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шудрага илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ОЧИРБАТ

# НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудитын гэрчилгээ

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

**С.Энхбаатар**
Нийслэлийн аудитын газрын дэд дарга
өрөөний утас 327744

**В.Эрдэнэцогт**
Санхүүгийн аудитын II албаны Менежер
өрөөний утас: 315558

**Ж.Энхтуяа**
Санхүүгийн II албаны III багийн аудитор
өрөөний утас: 325093

**ТАБ-ын хаяг**: Нийслэлийн аудитын газар
**Байршил**: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, Ж.Лхагвасүрэнгийн гудамж, Нийслэлийн засаг захиргааны V байр
**E mail:** ub@audit.mn
**Манай вэб: www.city.audit. mn**

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2 дугээр зүйлд заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-2017/544/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Биеийн тамир спортын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, системийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 05–ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын Санхүүгийн аудитын II албаны III багийн аудитор Ж.Энхтуяа 2017 оны 2 дугаар сарын 05-ны хооронд хийж гүйцэтгэв.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2017 оны 2 дугаар сарын 20-нд Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны удирдлагад хүргүүллээ.

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Биеийн тамир спортын тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 1.1.*" биеийн тамир, спортын зохион байгуулалт, эдийн засаг, эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнд оролцогчдын хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино."* гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д *"төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна"* гэж заасны дагуу Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны санхүүжилийг Нийслэлийн төрийн сангаас олгож байна.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим , түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

/ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан

мөрдөн ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн програм уялдаж байгаа бөгөөд УСНББОУС-тай нийцсэн байна.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ гарсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад хөрөнгөд бүртгэлээр тавих дотоод хяналт хэвийн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг НББ-ийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

## Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Нийслэлийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хороо нь 2016 онд төсвөөс санхүүжилт 378,965.4 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 9,000.0 мянга, орон нутгаас 305,021.0 мянга, үндсэн үйл ажилагааны орлого 9,400.0 мянга, бусад орлого 1,069.2 мянга нийт 694,055.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Үүнээс урсгал зардалд 374,752.1 мянган төгрөгийг зарцуулж, тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 4,213.3 мянга, нэмэлт санхүүжилтийн дансны 5,028.6 мянга нийт 9,241.9 мянган төгрөгийг нийслэлийн төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

## Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2016 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2016 оны 4, 10 дугаар саруудад нийцлийн аудит хийгдсэн болно.

## Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Санхүүгийн тайланд өөрийн байгууллагын эзэмшил газарт чацарганы суулгац авч суулгасан боловч чацарганы модоо данс бүртгэлд бүртгээгүй зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь төсвийг үр ашиггүй зарцуулах, тайлан мэдээ буруу гаргах, зарим хууль тогтоомж хэрэгжихгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

## Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 100.0 мянган төгрөгөөс дээш /мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад орлого, цалин хөлс, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, бичиг хэрэг, тээвэр шатахуун/ дүн бүхий ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 65.0 хувь, мөнгөн хөрөнгийн 85.0 хувь, нийт зардлын 75.0 хувь, нийт хөрөнгийн 45.0 хувийг тус тус эзэлж байна.

## Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус 300.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ .Үүнд:

1. Өөрийн байгууллагын эзэмшил газарт чацарганы суулгац авч суулгасан боловч чацарганы модоо данс бүртгэлд тусгаагүй нь Сангийн сайдын 388 дугаар тушаал Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар "*4.31 үндсэн хөрөнгө хүлээн зөвшөөрөх*" зөрчсөн байна.

   - Шийдвэрлэсэн: Мод, бут, сөөгийг бүртгэн санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах зөвлөмж өглөө.

## Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 300.0 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

## Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

## Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар улсын шинж чанартай тэмцээн уралдаанд оролцож байгаа гадаад, дотоодын тамирчдад олгож байгаа урамшуулал, тэдгээрт зарцуулж байгаа зардлын гүйцэтгэлийг авч үзэх болно.

## Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 300.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

## Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан

үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 5.. хуудас, хавсралтууд ... хуудас, байгууллагын санал 1.. хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

| | | | |
|---|---|---|---|
| | **ДЭД ДАРГА** | | **С.ЭНХБААТАР** |
| | **АУДИТЫН МЕНЕЖЕР** | | **В.ЭРДЭНЭЦОГТ** |
| **БЭЛТГЭСЭН:** | **АУДИТОР** | | **Ж.ЭНХТУЯА** |

# НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРООНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Менежментийн захидал

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

Асуудал 1

Хөрөнгө ...............3

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

**С.Энхбаатар**
Нийслэлийн аудитын газрын дэд дарга
өрөөний утас 327744

**В.Эрдэнэцогт**

Санхүүгийн аудитын II албаны
Менежер
өрөөний утас: 315558

**Ж.Энхтуяа**
Санхүүгийн II албаны III багийн аудитор

**ТАБ-ын хаяг**: Нийслэлийн аудитын газар
**Байршил**: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг,
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны V байр
**E mail:** ub@audit.mn

**Манай вэб: www.city.audit. mn**

## Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн Аудитын газрын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2017 оны 2 дугаар сарын 20

Я. Самбуужамц
Ц. Отгон
II/13

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө
Утас: 31-27-85, Факс: (976-11) 32-89-77
E-mail: it@sport.ub.gov.mn
http://www.sport.ub.gov.mn

2017.02.10 № 1/45

танай ______________-ны №______________-т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийсэн тухай ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа тусгаж ажиллах болно.

ДАРГА Ж. ГАНБОЛД

115050005

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 5,107,125.00 | 3,797,975.00 |
| БАРАА МАТЕРИАЛ | 4,107,125.00 | 3,797,975.00 |
| Хангамжийн материал | 4,107,125.00 | 3,797,975.00 |
| Бичиг хэргийн материал | 1,113,650.00 | 502,500.00 |
| Аж ахуйн материал | 2,393,475.00 | 3,295,475.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 25,367,551.24 | 19,621,147.58 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 25,367,551.24 | 19,621,147.58 |
| Биет хөрөнгө | 25,367,551.24 | 19,621,147.58 |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 22,376,202.00 | 22,376,202.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (19,906,010.75) | (22,376,202.00) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,253,379.90 | 42,853,379.90 |
| Хуримтлагдсан элэгдэл | (15,356,019.91) | (23,232,232.32) |
| Програм хангамж | 280,000.00 | 280,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (280,000.00) | (280,000.00) |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 30,474,676.24 | 23,419,122.58 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **30,474,676.24** | **23,419,122.58** |
| Засгийн газрын хувь оролцоо | 30,474,676.24 | 23,419,122.58 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 58,011,395.49 | 58,011,395.49 |
| Өмч: - төрийн | 58,011,395.49 | 58,011,395.49 |
| Хуримтлагдсан үр дүн | (27,536,719.25) | (34,592,272.91) |
| Өмнөх үеийн үр дүн | (15,387,651.68) | (32,657,922.42) |
| Тайлант үеийн үр дүн | (12,149,067.57) | (1,934,350.49) |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **30,474,676.24** | **23,419,122.58** |

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 648,332,800.00 | 686,186,412.00 |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 385,106,000.00 | 378,565,412.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 335,106,000.00 | 369,565,412.00 |
| Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 50,000,000.00 | 9,000,000.00 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 263,226,800.00 | 307,621,000.00 |
| Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 263,226,800.00 | 305,021,000.00 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 19,286,617.37 | 9,469,215.02 |

| | | |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,200,000.00 | 9,400,000.00 |
| Бусад орлого | 5,248,581.61 | 69,215.02 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 2,600,000.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 680,768,484.94 | 697,589,977.51 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 680,768,484.94 | 697,589,977.51 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 653,627,446.57 | 676,626,850.49 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 109,148,828.00 | 107,484,529.00 |
| Үндсэн цалин | 106,348,828.00 | 107,484,529.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,468,192.00 | 11,817,953.00 |
| Тэтгэврийн даатгал | 7,226,292.00 | 6,437,453.00 |
| Тэтгэмжийн даатгал | 848,400.00 | 672,400.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,060,500.00 | 1,344,800.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 212,000.00 | 672,400.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 2,121,000.00 | 2,690,900.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 3,446,600.00 |
| Түлш, халаалт | - | 3,446,600.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 12,778,397.00 | 8,821,891.00 |
| Бичиг хэрэг | 2,844,500.00 | 886,900.00 |
| Тээвэр, шатахуун | 6,815,673.00 | 6,192,580.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,118,224.00 | 1,742,411.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | - | 2,000,000.00 |
| Урсгал засвар | - | 2,000,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 197,738,782.00 | 223,214,421.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 196,401,622.00 | 221,954,421.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 34,600.00 | 906,400.00 |
| Газрын төлбөр | 370,060.00 | 353,600.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 322,283,247.57 | 319,841,456.49 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 308,434,982.32 | 314,616,256.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,848,265.25 | 5,225,200.49 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,141,038.37 | 20,963,127.02 |
| Бусад урсгал шилжүүлэг | 19,955,800.00 | 11,721,170.00 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 570,000.00 | 2,000,000.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,385,800.00 | 9,721,170.00 |
| Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,185,238.37 | 9,241,957.02 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,185,238.37 | 9,241,957.02 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (13,149,067.57) | (1,934,350.49) |
| НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (13,149,067.57) | (1,934,350.49) |

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 667,619,417.37 | 694,055,627.02 |

| | | |
|---|---|---|
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 648,332,800.00 | 683,586,412.00 |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 385,106,000.00 | 378,565,412.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 335,106,000.00 | 369,565,412.00 |
| Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 50,000,000.00 | 9,000,000.00 |
| Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 263,226,800.00 | 305,021,000.00 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 19,286,617.37 | 10,469,215.02 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,200,000.00 | 9,400,000.00 |
| Бусад орлого | 5,248,581.61 | 1,069,215.02 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 667,620,519.69 | 694,055,627.02 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 667,620,519.69 | 694,055,627.02 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 659,865,281.32 | 682,813,670.00 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 108,748,827.00 | 107,484,529.00 |
| Үндсэн цалин | 105,948,827.00 | 99,884,529.00 |
| Нэмэгдэл | - | 7,600,000.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,468,193.00 | 11,817,953.00 |
| Тэтгэврийн даатгал | 7,226,293.00 | 7,517,753.00 |
| Тэтгэмжийн даатгал | 848,400.00 | 537,400.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,060,500.00 | 1,074,800.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 212,000.00 | 537,400.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 2,121,000.00 | 2,150,600.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,130,000.00 | 13,167,770.00 |
| Түлш, халаалт | - | 3,446,600.00 |
| Байрны түрээс | 5,130,000.00 | 9,721,170.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 11,592,240.00 | 9,168,323.00 |
| Бичиг хэрэг | 2,668,500.00 | 1,348,000.00 |
| Тээвэр, шатахуун | 5,755,516.00 | 6,192,580.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,118,224.00 | 1,627,743.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | - | 4,000,000.00 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 2,000,000.00 |
| Урсгал засвар | - | 2,000,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 209,934,729.00 | 228,686,019.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 208,423,769.00 | 226,980,171.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 208,400.00 | 1,352,248.00 |
| Газрын төлбөр | 370,060.00 | 353,600.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 312,781,292.32 | 308,489,076.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,755,238.37 | 11,241,957.02 |
| Бусад урсгал шилжүүлэг | 570,000.00 | 2,000,000.00 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 570,000.00 | 2,000,000.00 |
| Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,185,238.37 | 9,241,957.02 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,185,238.37 | 9,241,957.02 |

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 58011395.49 | 0.00 | (27536719.25) | 0.00 | 30474676.24 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (5121203.17) | | (5121203.17) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 58011395.49 | 0.00 | (32657922.42) | 0.00 | 25353473.07 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (1934350.49) | | (1934350.49) |
| 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 58011395.49 | 0.00 | (34592272.91) | 0.00 | 23419122.58 |

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү /+илүү, -дутуу/ | Гүйцэтгэлийн хувь Хувь |
|---|---|---|---|---|
| I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V) | 378,965,300.00 | 374,752,094.00 | (4,213,206.00) | 98.89 |
| II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV) | 378,965,300.00 | 374,752,094.00 | (4,213,206.00) | 98.89 |
| III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 378,965,300.00 | 374,752,094.00 | (4,213,206.00) | 98.89 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 378,965,300.00 | 374,752,094.00 | (4,213,206.00) | 98.89 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 107,522,000.00 | 107,484,529.00 | (37,471.00) | 99.97 |
| Үндсэн цалин | 99,922,000.00 | 99,884,529.00 | (37,471.00) | 99.96 |
| Хоол унааны хөнгөлөлт | 7,600,000.00 | 7,600,000.00 | - | 100.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,827,300.00 | 11,817,953.00 | (9,347.00) | 99.92 |
| Тэтгэврийн даатгал | 7,527,100.00 | 7,517,753.00 | (9,347.00) | 99.88 |
| Тэтгэмжийн даатгал | 537,400.00 | 537,400.00 | - | 100.00 |
| ҮОМШ өвчний даатгал | 1,074,800.00 | 1,074,800.00 | - | 100.00 |
| Ажилгүйдлын даатгал | 537,400.00 | 537,400.00 | - | 100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Байгууллага төлөх ЭМД-ын хураамж | 2,150,600.00 | 2,150,600.00 | - | 100.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 257,616,000.00 | 253,449,612.00 | (4,166,388.00) | 98.38 |
| Түлш, халаалтын зардал | 8,603,800.00 | 3,446,600.00 | (5,157,200.00) | 40.06 |
| Бичиг хэргийн материал | 992,000.00 | 1,348,000.00 | 356,000.00 | 135.89 |
| Тээвэр, шатахууны зардал | 6,200,000.00 | 6,192,580.00 | (7,420.00) | 99.88 |
| Шуудан холбооны зардал | 1,983,100.00 | 1,627,743.00 | (355,357.00) | 82.08 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | 835,700.00 | 353,600.00 | (482,100.00) | 42.31 |
| Харуул, хамгаалалтын зардал | 2,430,000.00 | 2,418,500.00 | (11,500.00) | 99.53 |
| Урсгал засварын зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал | 224,245,700.00 | 222,989,171.00 | (1,256,529.00) | 99.44 |
| Бусад зардал | 1,762,500.00 | 1,352,248.00 | (410,252.00) | 76.72 |
| Байрны түрээсийн зардал | 6,563,200.00 | 9,721,170.00 | 3,157,970.00 | 148.12 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР: | 378,965,300.00 | 374,752,094.00 | (4,213,206.00) | 98.89 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,400,000.00 | 9,400,000.00 | - | 100.00 |
| Төсвөөс санхүүжих | 369,565,300.00 | 365,352,094.00 | (4,213,206.00) | 98.86 |
| Байгууллагын тоо | 1 | 1 | - | 100.00 |
| Ажиллагсад бүгд | 8 | 8 | - | 100.00 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 | - | 100.00 |

## АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Батлагдсан төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл |
|---|---|---|
| III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | | 314,274,933.02 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | | |
| Бараа ,үйлчилгээний урсгал зардал | | |
| Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал | | 314,274,933.02 |
| Бусад зардал | | |
| Байрны түрээсийн зардал | | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | |
| VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР: | | 319,303,533.02 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| Төсвөөс санхүүжих | | 319,303,533.02 |